

АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 06-НЫ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГСӨН ҮҮРЭГ, ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ

2023.09.08

Баянтал сум

№	Үүрэг даалгавар	Биелэлт	
1	Нохой, муур устгах ажлыг зохион байгуулах	100	Өнгөрсөн 2023.04.05-ний өдөр иргэн Б.Будтай нохой, муур устгах ажлын гэрээ байгуулж ажилласан. Нийт 52 нохой, 5 муур устгах ажил хийгдсэн.. 2023.09.14-ний өдөр нохой, муур устгах ажил хийгдлээ. Нийт 27 нохой, 5 муур усгасан. Хойшид устгалын ажил үргэлжлэн хийгдэнэ.
2	Ус дулаан хангамжийн байгууллагууд өвөлжилтийн бэлтгэл ажлыг эрчимжүүлэх	90	Сүлжээний насосд засвар үйлчилгээ хийсэн. Бохирын насос станц, цэвэр усны худгууд барилга, насосд урсгал засвар хийгдэж дууссан. 154-р барйны подволын дулаан цэвэр усны шугамыг шинэчлэх ажил бүрэн хийгдэж дууссан. 105, 152-р байрны подволын шугам хоолойн хаалт, винтелийг сольж засварласан. Бохирын хаялагын цэгийг хамгаалах тор шонг сэргээн засварласан. Цэвэр болон дулааны худгуудад урсгал засвар хийж 5 ш хаалт сольсон. Биелэлт 90 хувьтай байна.
3	Нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах, төрийн байгууллагууд өөрийн эзэмшил газар болон хариуцсан талбайн хог хаягдал, шарилж, зэрлэг ургамлыг түүж цэвэрлэх ажлыг эрчимжүүлэх	100	2023.09.05-ны өдөр босоо тэнхлэгийн автозам дагуух болон 14, 16-р зөрлөгт байрлах түр зогсоолын цэгүүдийн хогийг Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, Эмнэлэг зэрэг төрийн байгууллагуудын албан хаагчид хамтран цэвэрлэгээ хийж, бие засах газар, хогийн цэгийг будан өнгийг сэргээлээ. Нийт 7 тн хог хаягдлыг зориулалтын хогийн цэгүүдэд асгасан. Сумын хэмжээнд нийтийн их цэвэрлэгээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр аж ахуй нэгж, байгууллагуудад ойр орчмын 50 метр хүртэлх газруудыг тогтмол цэвэрлүүлэн ажиллаж байна.
4	Монгол Улсын Ерөнхий Сайдын Говьсүмбэр аймгийн иргэдтэй хийх уулзалтад байгууллагууд албан хаагчдаа оролцуулах, сумдууд	100	2023.09.07-ны өдөр Монгол Улсын Ерөнхий Сайд, Засгийн Газрын гишүүд Говьсүмбэр аймгийн иргэд, албан хаагчидтай хийх уулзалт зохион

	иргэдээ оролцуулахад анхаарч ажиллах		байгуулагдлаа. Энэхүү уулзалтад сумын ЗДТГазар, Аж ахуй нэгж, албан байгууллага, иргэд, ахмадын төлөөллүүд оролцсон.
--	--------------------------------------	--	----------------------------------------------------------------------------------------------------------------------

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

СУМЫН ЗДТГАЗРЫН ДАРГА

ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

Ц.ЛХАГВАДОНИД

Б.ГАНБАЯР